

## ЗҮҮН ГАРЫН ОТГИЙН АСУУДАЛД

И.Саруул, З.Батсайхан, Д.Долгорсүрэн

Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Угсаатан судлалын тэнхим.

**Өгүүлэлийн товч:** Монголын дундад зууны түүхэнд баруун монголчуудын нийгэмд чухам хэзээ отог байгуулагдаж, ямар үр дүнд хүрснийг харуулах бүтээл өнөө хир үгүй байгаа билээ. Тиймээс зохиогчид сэдэвлэн нягтлахад 1700 оны орчим ойрадын Цэвээнравдан хаан анх зүүн гарт отог байгуулж, түүний хүү Галданцэрэн хаан шинэтгэлийг нь үргэлжлүүлэн нэмж отог байгуулан улмаар язгууртан ноёдын эрх мэдлээрээ далимдуулан дураар аашлахыг таслан зогсоож, хааны нэгдсэн удирлаганд оруулж авсан байна. Тэгсэнээр ойрад нь феодалын улсын зохион байгуулалтанд шилжиж, цэцэглэн мандахад хүрчээ.

**Түлхүүр үг.** Баруун монголчуудын отгийн зохион байгуулалт нь феодалын төр улсын засаг захиргааны зохион байгуулалт мөн.

Аливаа улс орны засаг захиргааны зохион байгуулалт нь тухайн ард түмний нийгэм-эдийн засаг, улс төрийн хөгжлийн түүхийг бодитоор нь гаргах нэгэн үндэслэл нь байдаг билээ. Зохиогчид тус өгүүлэлдээ дундад зууны үеийн Монголын тусгаар тогтнолын сүүлчийн тулгуур болсон Зүүн гар улсын захиргааны хуваарийн отгийн асуудлыг авч үзэв. Анх академич Н. Ишжамц 1966 онд “БНМАУ-ын түүх”-ийн II ботид: - **“Бүгд бодвол тэдний хааны хорин дөрвөн отог ... буй”** (1.т.132.) гэж Л. Дэндэвийн монгол хэлнээ орчуулсан “Тэнгэрийн тэтгэсэн хааны богд сургаал” сурвалжаас иш татаж судалгаа шинжилгээний эргэлтэнд оруулжээ. Түүний удаад Д. Гонгор “Халх товчоон” бүтээлдээ: - **“Дөрвөн ойрадын байдлыг авч үзэхүл хааны хорин дөрвөн отог ... байсан”** (1.т.262.) гэснээс өөр баримт судалгаа хараахан байхгүй тул Зүүн гарт чухам хэзээ, ямар үндэслэлээр отог байгуулагдсаныг нягтлах шаардлагатай.

Сурвалж болон судалгааны зохиолуудыг сөхөхөд Цэвээнравдан (1697-1727) ханы засаглалын үед зүүн гарт анх отог байгуулагдсан мэдээ сэлт тэмдэглэгджээ. Отог байгуулах болсон шалтгаан нь: - нэгд, Галдан бошогт хан 1688 онд манжийн цэрэгт ялагдсаны улмаас Зүүн гарын улс төр, нийгэм эдийн засаг уналтанд орж, улс орны оршин тогтнол, ард түмний аж байдал хүндхэн байдалтай болжээ; - *хоёрт*, Халх Монгол манжид эзлэгдсэнээр Ойрад нь Монгол улсын баруун хязгаарын жигүүр байхаа больж, гагцаар тогтноход хүрчээ; - *гуравт*, Дөрвөн ойрад аймгийн дөрвөн их тайжийн улс төр, эдийн засгийн хүчин чадал, эрх мэдэл ихэсч дураар авирлах болсон. Цэвээнравдан хунтайж ойрадыг захирч хан суухад ойрад аймгийн ихэс язгууртнууд эрх мэдэл булаалдан тэмцэхийн хамт тэргүүлэгч ханы төв засаглалын эрч суларчээ. Энэхүү төрийн хямрал нь зүүн гарыг задран нурахад хүргэж байв; - *дөрөвт*, Манжийн Чин гүрнээс байнга түрэмгийлэн эзлэх дайны ажиллагаа өрнүүлж байсантай холбоотой зүүн гарын цэрэгжсэн батлан хамгаалах хүчин чадал нь суларч, улмаар харийн түрэмгийлэгчдэд автах аюул тулгарчээ; - *тавд*, Ойрадын төрийн тогтолцоо, цэрэг дайны бэлтгэл, нийгэм аж ахуйн хөгжил, засаг захиргааны зохион байгуулалт, ханы төвлөрсөн засаглал гэх мэт нь Зүүн гар улсын оршин тогтнолтой нь зохицолдохгүй болсон байв; - *зургаад*, Зарим туйлбаргүй ноёд тайж нар эмх замбраагүй байдлаар далимдуулан манжид дагаар орцгоох болсон зэрэг олон зөрчлүүд шил дараалан хуримтлагджээ.

Эдгээр зэрэг хүчин зүйлүүдийн улмаас баруун монголчууд нь Халх Монголыг 1691 онд манжийн эрхшээлд автсаны дараа тусгаар тогтнолоо сахиж орших уу? эс сахиу уу? бэрхшээлтэй тулгарсан. Энэ хүнд цагт Цэвээнравдан хаан ойрадчуудын тусгаар тогтнолыг хамгаалж, улс орондоо дорвитой шинэчлэлт өөрчлөлтийг хэрэгжүүлж эхэлжээ. Тэрээр Тэнгэр уулын ар дахь дөрвөн ойрадыг засаг захиргааны талаар: *үрүд, харчин, эрхтэн, хиргүд,*

зүтлүг, бүхүс, авгас хадан, эвид, гүрбэс, цохор, оротай, доглод гэсэн эхний арван хоёр отогт зохион байгуулсан байна.

Ингэснээр дөрвөн ойрад аймгийн тэргүүн их тайж нарын улс төр, эдийн засгийн сүр хүчийг таслан зогсоож, тэдний захиргааны харъяат албат нарыг нь арван хоёр отогт хуваарилан, хааны тушаалаар томилогдсон отгийн захирагч тайж нарт эрх мэдлийг нь олгожээ. Тэгсэнээр дөрвөн ойрад аймгийн урьд өмнөх нийгэм эдийн засгийн харилцаа холбоо сэргэж, нэгэн ноёны харъяаны эзэмшил төдий Монгол улсын зах хязгаарын нэгэн жигүүр мужийн байдлаас гарч феодалын нийгэм эдийн засгийн байгуулалттай, хааны төв засаглалтай төр улсын шинжтэй болжээ. Үүнд Цэвээнравдан хааны түүхэнд гүйцэтгэсэн гавъяа зүтгэл нь оршино.

Цэвээнравданы хүү Галданцэрэн хаан (1727-1745) гарч ирэхэд Зүүн гар улсад: - *нэгд*, Дөрвөн ойрад аймгийн тэргүүлэгч их тайж нарын эрх мэдэл Цэвээнравдан хааны үед хэдий хязгаарлагдсан боловч тэдний сүр хүчин, нөлөө нь хэвээр байжээ; - *хоёрт*, Их, Бага хоёр Цэрэндондов, Үйзэн хошууч болон Лувсанцэрэн тавнан мэтийн сурвалжит тайж зайсан нарын харъяат отгийн хүн ам нь таван түм (5000) гаруй болж, цэрэг засгийн эрхийг хослуулан атгаж, байр суурь нь өдөр ирэхүйе товойсон байна. Аж ахуй, эдийн засгийн талаар тэд бас их хэмжээний эд бодис, хөрөнгө хурааж, улмаар хүч нөлөө нь ихсэж, бие даан тусгаарлах хандлагатай болсон; - *гуравт*, Галданцэрэн хааны үед Зүүн гар нь орон нутгаа тэлэхийн тулд удаа дараалан цэрэгжсэн үйл ажиллагааг амжилттай өрнүүлж ирсний дүнд Халх Монгол, Алтайн аймгуудын эзэмшил, Казах, Киргиз, Дорнод Туркестаны газар нутгуудыг эзэлж авсан байна. Тиймээс шинэ отгууд байгуулагдсан нь ойрадын түрэмгийлэн эзлэх дайны явцад нутаг дэвсгэр нь тэлсэнтэй холбоотой. Тухайлбал, Шарас ба махус отгууд Кашгарт, мянгад отог Ховд хязгаарт тус тус байгуулагджээ. Үндсэндээ ойрадын ноёд тайж нарын засаглалын хямралаас болж Зүүн гар улсын улс төр, нийгэм аж ахуйн хөгжил, цэргийн нэгдсэн удирдлага хүндэрч байсан тул Цэвээнравдан хааны эхлүүлсэн улсын шинэчлэлийг гүнзгийрүүлэх шаардлагатай байв.

Галданцэрэн хаан Зүүн гар улсынхаа засаглалын зохион байгуулалтыг 1734 оноос 1738 оны хооронд дөрвөн жилийн хугацаанд хэрэгжүүлжээ. Цэвээнравдан ханы үед байгуулагдсан арван хоёр отгийг шинэчилж зохион байгуулахын зэрэгцээ шинээр захиргаандаа авсан нутаг зэрэгт нэмж арван хоёр отог, хорин нэгэн ангийг (цэрэгжсэн хороо – И.С.) тус тус байгуулсан байна. Тэдгээр нь: *Бардамад, галжид, шарас, махус, бүгүнүд урад, алтчин, хөтөчнар, захчин, теленгэд, хиргис, мянгад* гэсэн арван хоёр байна. Тэгсэнээр Галданцэрэн хааны үед Зүүн гар улс нь нийт 24 отогтой болж, Цэвээнравдан хааны үед байгуулагдсан эхний 12-ыг *хуучин*, сүүлийн 12 отгийг *шинэ* буюу *сүүлийн* гэж тус тус нэрийджээ. Оросын эрдэмтэн А.И. Чернышевский нангиад сурвалжийг үндэслэн хийсэн зүүн гарын отгийн хүснэгт (З.т.116-117.):

**12 “старых” отоков Джунгарского ханства.**

№	Отоки	Число зайсанов	Число дворов (тыс.)	Число отоков
1	Улутэ	4	5	1
2	Калацинь	1	5	1
3	Кээркэтэн	1	5	1
4	Кэлиятэ	2	6	1
5	Чжотолукэ	1	3	1
6	Букусы	1	3	1
7	Абахэсы и Хэдань	2	4	1
8	Обитэ	1	3	1
9	Олодай	2	3	1

10	Доголутэ	1	4	1
11	Хоэрбосы	1	3	1
12	Чжохээр	1	3	1
	<b>Итого...</b>	<b>18</b>	<b>47</b>	<b>12</b>

**12 “иновых” отоков Джунгарского ханства.**

№	Отоки	Число зайсанов	Число дворов (тыс.)	Число отоков
1	Баэрдамутэ	3	4	1
2	Кутуцинаэр	5	4	1
3	Хээрцзатэ	3	4	1
4	Шаласы	2	3	1
5	Махусы	1	5	1
6	Букунутэ и Тугутэ	2	2,5	1
7	Улатэ	1	3	1
8	Аэртацинь	1	0,5 (5)	1
9	Чжахэцинь и Баоцинь	3 нэмэх 3	2 нэмэх 1	1
10	Цзиэрцзисы	4	4	1
11	Тэлэнгутэ, Оэрчукэ и Уэрханьцзилань	4 нэмэх 1 нэмэх 1	4 нэмэх 0,5 нэмэх 0,8	1
12	Минъатэ	2	3	1
	<b>Итого ...</b>	<b>36</b>	<b>41,3 (45,3)</b>	<b>12</b>

Өвөрмонголын судлаач Намсрай “Зүүн гар хаант улс” (Өвөрмонгол, 1996) номондоо Тэнгэрийн тэтгэгч хааны 28 оны (1663 он) “Дайчин улсын магад хууль” сурвалжийн “Зүүн гарын бүрэн тэмдэглэл” хэсгийг баримтлан гаргасан хүснэгт (4):

**Хуучин арван хоёр отог**

№	Отгийн нэрс	Өрхийн тоо	Зайсангийн тоо
1	Үрүд	5000	4
2	Харчин	5000	1
3	Эрхтэн	5000	1
4	Хиргуд	6000	2
5	Зүтүлүг	3000	1
6	Бүхүс	3000	1
7	Авгас хад	4000	2
8	Эвид	3000	1
9	Доглод	4000	1
10	Гүрбэс	3000	1
11	Цохор	3000	1
12	Оротай	3000	2

**Сүүлийн арван хоёр отог**

№	Отгийн нэрс	Өрхийн тоо	Зайсангийн тоо
1	Бардамад	4000	3
2	Хөтөчнар	5000	5
3	Галжид	4000	3
4	Шарас	3000	2
5	Махус	5000	1
6	Бүгүнүд	2500	2
7	Урад	3000	1

8	Алтчин	5000	1
9	Захчин	3000	6
10	Хиргис	4000	4
11	Теленгэд	5300	6
12	Мянгад	3000	2

Сурвалж судалгааны зохиолд Галданцэрэн хааны засаглалын сүүлийн жилүүдэд Зүүн гарын отгийн тоо 30 хүрч байжээ. Өвөр Монголд нийтлэгдсэн “Ойрадын түүхэн сурвалж бичиг”-т жагсаасан нь (5.т.131-133.):

**Зүүн гарын хаант улсын отог ба жасын тоо бүртгэлийн хүснэгт.**

№	Засаг захиргааны нэрс	Зайсангийн тоо	Өрхийн тоо
1	Үрүд отог	4	5000
2	Харчин отог	1	5000
3	Хэрэйд отог	1	6000
4	Зодрог отог	1	3000
5	Бүхүс отог	1	3000
6	Авгас хад отог	2	4000
7	Эвид отог	1	3000
8	Эрхтэн отог	2	3000
9	Түхүрүд отог	1	4000
10	Зэлбэс отог	1	3000
11	Чохор отог	1	3000
12	Баргамад отог	3	4000
13	Хөтөчнар отог	5	4000
14	Галзуд отог	5	4000
15	Шарас отог	1	3000
16	Махус отог	1	5000
17	Бүгүнүд отог	1	2000
18	Түгүд отог	1	500
19	Урад отог	1	3000
20	Артачин отог	1	500
21	Захчин отог	3	2000
22	Пуучин отог	3	1000
23	Хиргис отог	4	4000
24	Теленгэд отог	4	4000
25	Эрцэг отог	1	500
26	Мянгад отог	2	3000
27	Уургын жирмэн жас отог	1	800

Нийт гучаад отгоос хорин дөрвөн нь жинхэнэ отог, бусад бүгүнүд, захчин, теленгэд, эрцэг дөрөв зэрэг нь жинхэнэ отгоор нэрлэгддэггүй байжээ. Эхний хорин дөрвөн отгоос сүүлд байгуулагдсан мангуд нь хиргис отогтой хамт Даваачийн үеийн дотоодын дайн байлдааны дунд эвдэрч, эрхтэн, бүхүс, баргумад гурван отог нь тухайн үед хасагт мөхөөгдсөн байна. Хиргис, теленгэд, мянгад зэрэг нь отоггүй байсныг Галданцэрэн хаан засаг олгон отог байгуулж, эрх мэдлийг олгожээ.

Галданцэрэн хаан хуучин арван отгийн бүрэлдэхүүнд байсан адил бус овог ястан, тэдний үндэстний түүхт байдлыг харгалзаж хуучин арван хоёр отгоос хүн ардыг нь салгаад шинэ арван хоёр отогт хуваарилжээ. Үрүд, урад, харчин, баргамад, галзуд зэрэг отгийн нэрсээс дөрвөн ойрад олон аймагт байсан

ястнуудын мөрийг олохын хамт хэрэйд, цохор, эрхтэн зэрэг отогт торгуудын Эзнээ тайшийн хойч үеийн захиргаан доор байсан махчин, хэрэйд хошоодын Очирт тайшийн эрхтэн отог, Хөх нуураас олзолсон халхын цоохор Цогтын харъяат албатууд нь хорин дөрвөн отогт тус тус зохион байгуулагдсан байна.

Үүнээс гадна захчин, буучин хоёр отог нь уйгур үндэстэн, хиргис отог нь бурууд үндэстнээс тус тус бүрэлджээ. Зүүн гарын хааны шууд захиргаан доорх эдгээр отгууд нь голдуу дотоод гадаадын дайн байлдааны явцад олзлогдсон хүмүүс юм.

Хөтөчнар, алтчин, захчин гурван отгийг улсын нийгмийн ажлын бодит хэрэгцээнд чиглүүлэн байгуулжээ. Бор талын баруун хойно буй Илийн зүүн хойдох Алтан түвшид тохируулсан хөтөчнар отог нь хааны орд өргөөг харж хамгаалах, нүүж шилжих, сэлбэн засах, мал сүрэг арчлах, эд бодисыг хангах, алба татвар хураах, зарлиг захиа уламжлах мэтийн ажилд тусгайлан үйлчилж байжээ. Алтчин отгийн хүмүүс нь улсын гар үйлдвэрлэлийг хариуцаж төмөр, зэс, гуулийг боловсруулж цутгах, давтах ба өдөр тутмын амьдралд хэрэглэх багаж, сав хэрэгслийг үйлдэхийн хамт бурханы хөрөг зурах, баримал шуух, сийлэх мэтийн ажлуудыг эрхэлжээ. Урд өмнө зүүн гарын хил хязгаарыг хамгаалах тусгай цэрэг анги байсангүй, зөвхөн хил дагуу орших дөрвөд болон урианхай аймгийн хүмүүсийг түшиглэж байсан. Улсын аюулгүй байдлыг сахих шаардлагаар чорос овогт хөгшин Мамуудын харьяатаар захчин отог байгуулж, зүүн гарын зүүн өмнөд хилийн Булган цагаан тохой болон Улаан усанд сэргийлэн суулгаж, хил хязгаарын сэргийлэлт ба харуул байцаалтын хэрэг явдлыг эрхлүүлжээ.

Отог зохион байгуулахдаа Галданцэрэн хаан сурвалжит тайж нарын нутаг бүрэлдэж болох нөхцлийг нь үндэслэж, отог бүрийн харъяат өрхийн тоог хоёр мянгаас зургаан мянгын хооронд тогтоожээ. Отгийн их бага, бүрэлдэхүүнийг нь харгалзаж нэгээс дөрвөн зайсанг тохоож засаг захиргааны ажлыг хариуцуулжээ. Отгийн доторх үндсэн шатны тушаалтныг томилохдоо зүүн гарын хуучин уламжлалыг журамлаж нэгээс хоёр зуун өрх бүрд дэмч хэмээх ноёныг томилон, хэдэн арван өрхийн дээр шүлэнгэ хэмээх тушаалтныг тавьжээ.

Эдгээр хорин дөрвөн отгийн дотор цөөхөн хэдэн отог нь Тэнгэр уулын өмнө Ёлтост, бусад нь Илийн баруунд буй Тэнгэр уулын ар дахь Исаак, Или, Цагаан ус, Хүнгүс, Бор тал, Эмиль, Тарвагайтай, Яр зэрэг газар орны тойрноор тархаж байршуулагдсан байна. Хиргис отог нь Исаак нуурын өмнө нутаглаж, доглод отог нь Исаак нуурын ар дахь Түргэн хэмээх газар малжиж, бүхүс отог нь доглодын баруун хойдох Хүрдэд суурьшчээ. Эрхтэн отог нь Хүрдийн зүүн хойд Балгас нуурын өмнөх Төвлөнд нутаглаж, Илийн баруун хойдох Хүрэнхүй уулын зүүн бэлд харчин, галжид хоёр отог тус тус малжиж, тэдний зүүн хойдох Илийн ар дахь Цагаан усанд алтчин отог нутаглажээ. Цагаан усны зүүнтэйх Алтан түвш болон Бор талын рашаан орчимд хөтөчнар отог байршиж, Илийн зүүн өмнөх Хүнгүс голд үрүд болон гүрбэс хоёр отог малжиж, тэдний зүүнтэйх Хаш голын эхэнд шарас, махус хоёр отог нутаглав. Хүнгүс голын өмнөх Ёлтос гол орчимд хиргүд, цохор хоёр отог оршиж, Хаш голын зүүн өмнө Богд эрээн хавирга уул сүндэрлэжээ. Түүний зүүн бэлд авгас хадан отог малжив. Өнийн Ховог сайрын ар дахь Улаан хужирт бүгүнүд отог нутаглаж, Эмилийн тал газарт эвид отог малжижээ (4.т.78.).

Галданцэрэн хааны шинэтгэлийн дүнд урьд хожид байгуулагдсан хорин дөрвөн отог нь аж ахуй, тариалан, гар урлал, үйлдвэрлэлийн хэргийг эрхэлж, ангиуд нь цэрэг цагдаа, хил хязгаарын хамгаалалтыг хариуцах болсон. Тэгснээр дөрвөн аймгийн их тайж, хуучин арван хоёр отгийн тайжийн эрх мэдлийг таслан хязгаарласан байна. Отог, ангийн тайж нарыг хааны төв засагт захирагдах журамд шилжүүлжээ.

Ийнхүү Цэвээнравдан, Галданцэрэн хаад ойрадын дотоод гадаад улс төр, нийгэм эдийн засгийн оршин тогтнол, цэрэг дайны хүчин зүйлүүдийг тооцоолж

хийсэн шинэтгэлийн дүнд сурвалжит язгууртаны эрх мэдлийн төлөө улс төрийн хямралыг таслан зогсоож, төрийн бодлого, хаант улсын дотоодын эв нэгдлийг бүрдүүлж, Зүүн гар улсаа мандуулсан байна. Отог байгуулагдсан явдал нь баруун монголчууд гагцаар тогтноход хүрэхэд зүгээр нэг феодал ноёны эзэмшил төдий бус, харин феодалын төр улсын хэлбэрээр оршин тогтнож, засаг захиргаа, шашин суртахуун, цэргийн талаар нарийн зохион байгуулалттай байсныг харуулж байна.

**Abstract:**

Administrative structure of every country serves as a ground for its social, economic and political development. However, there is a gap in research on the medieval history of the *otog* (a medieval autonomous administrative unit roughly equivalent to polity) system among the Juun Gar Mongols, and there is not enough information what were the causes and territorial origins of the emergence of the *otog* system in the state of the Juun Gar Mongols.

Recently, the scholars from Russia and Inner Mongolia are addressing this issue; their publications offer us some sources to study the political and economic development of the tribal system in the Juun Gar state. The first 12 *otog* of the Juun Gar Mongols emerged during the reign of Tsevenravdan Khan (r. 1691-1727) and the last 12 *otog* – during the reign of Galdantseren Khan (r. 1727-1755); their history reveals that initially there were a total of 24 *otog*, later enlarged with six more *otog* of the conquered neighboring countries, making the final 30.

Possible causes for the emergence of the *otog* system was to unite the individual clans and limit the authority of their chieftains, as well as to promote the social and economic development of the Juun Gar state.

Consequently, the Juun Gar state was developed from a feudal confederation to a unitary feudal kingdom with complex administrative structure and powerful religious and military influence in Central Asia.

**Ашигласан ном зохиол.**

1. "БНМАУ-ын түүх". Боть П. - УБ., 1966.
2. Гонгор Д. Халх товчоон. – УБ., 1978.
3. Чернышев А.И. Общественное и государственное развитие ойратов в XVIII в. - М., 1990.
4. Намсрай. Зүүн гарын хаант улсын түүх. - Өвөрмонгол, 1996.
5. "Ойрад түүхэн сурвалж бичиг". – Бадай, Алтан-Оргил, Эрдэнэ нар эмхэтгэн тайлбарлав. - Өвөр Монгол, 1985.